



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ДОТООД АУДИТЫН ХОРООНЫ ТОГТООЛ

2025 оны 12 сарын 25 өдөр

Дугаар 06

Сүхбаатар сум

Г 2025 оны 4 дугаар улиралд хийсэн санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитын дүнгийн тухай

Төсвийн тухай хуулийн 69.3, Монгол улсын Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан "Дотоод аудитын дүрэм"-ийн 7.7, Сангийн Сайдын 2019 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Дотоод аудитын хорооны дүрэм"-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. 2025 оны хяналт шалгалтын төлөвлөгөөнд тусгагдсан Хүдэр сумын ТТЗ-ийн 2024, 2025 оны үйл ажиллагаанд дотоод аудит, Сэлэнгэ аймгийн Засаг даргын Тамгын газар, Хүдэр сумын Засаг даргын Тамгын газар, Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Баруунбүрэн сумын Орхон бүсийн сум дундын ой анги, Цагааннуур сумын Сэлэнгэ сум дундын ойн ангийн 2024, 2022 оны 2 дугаар улирлын санхүүгийн үйл ажиллагаанд тус тус хийсэн санхүүгийн хяналт шалгалтын илэрсэн зөрчлийн дүн, дүгнэлтийг хавсралтаар баталсугай.

Хоёр. Санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитаар илэрсэн зөрчил дутагдлыг тогтоосон хугацаанд бүрэн арилгах, байгууллагын засаглал, эрсдэлийн удирдлага, үйл ажиллагааны дотоод хяналтыг сайжруулах чиглэлээр өгсөн дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлж, төсвийн сахилга бат, үр ашиг, үр нөлөө, ил тод байдлыг ханган ажиллах арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллахыг зөвлөсүгэй.

Санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитаар илэрсэн зөрчил дутагдлыг тогтоосон хугацаанд бүрэн арилгах, байгууллагын үйл ажиллагаанд өгсөн дүгнэлтийг сайжруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллахыг Орон нутгийн өмчит ААТҮГ-ын захирал, төсвийн байгууллагын дарга нарт даалгасугай.

Гурав. Дотоод аудитын хорооны тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нарийн бичгийн дарга (Т.Мөнхзул)-д үүрэг болгосугай.

Хорооны дарга:

Н.Лхагвадорж
(Аймгийн Засаг дарга)

Нарийн бичгийн дарга:

Т.Мөнхзул
(Ахлах дотоод аудитор)

Гишүүд:

Т.Одсүрэн
(Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын дарга)



Ө.Сувдаа
(Аймгийн Засаг даргын
Тамгын газрын дарга)



Б.Энхтуяа
(Санхүү төрийн сангийн хэлтсийн
дарга)



Б.Янжинлхам
(Хууль эрх, зүйн хэлтсийн дарга)



А.Дашбат
(Иргэний төлөөлөл)



А.Гэрэлмаа
(Иргэний төлөөлөл)

Дотоод аудитын хорооны 2025 оны 12 дугаар сарын 28-ны
өдрийн 06 дугаар тогтоолын хавсралт

ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ЖАГСААЛТ



(мян.төг)

д/д	Байгууллагын нэр	Илэрсэн зөрчлийн дүн	Эрсдэлийн үнэлгээ
1	Орхон бүсийн сум дундын Ойн анги	35,752.1	"Дунд" эрсдэлтэй
2	Сэлэнгэ бүсийн сум дундын Ойн анги	9,700.0	"Бага" эрсдэлтэй "
3	Хүдэр сумын Засаг дарга	777,282.9	"Сайжруулах шаардлагатай"
4	Хүдэр сумын Засаг даргын Тамгын газар	5,171.7	"Дунд" эрсдэлтэй
5	Хүдэр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	6,730.0	"Дунд" эрсдэлтэй
Дүн		834,636.7	